

**“Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах (SIFS)
дэд хөтөлбөр”-ийн 10 дахь удаагийн санхүүгийн үүсмэл хэлцэл хийгдлээ**

Монголбанкнаас жижиглэнгийн нефтийн бүтээгдэхүүний эрсдлийг бууруулж, жижиглэнгийн борлуулалтын үнийг тогтвортой байлгах механизм бий болгох зорилгоор SIFS дэд хөтөлбөрийг Уул уурхайн яамтай хамтран 2012.10.26-ны өдрөөс хэрэгжүүлж байгаа билээ.

Энэхүү дэд хөтөлбөрт заасны дагуу хэрэгжүүлэгч компани нь тус хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн зээлийн шугамын эрхийн дүнг 3 дахин нэмэгдүүлснээс ихгүй хэмжээний санхүүгийн үүсмэл хэрэгслийг оролцогч банкаар дамжуулан Монголбанктай хийх нөхцөл бүрдсэн.

Хөтөлбөрийн 10 дахь удаагийн санхүүгийн үүсмэл хэрэгслээр оролцогч банкаар дамжуулан “Шунхлай” ХХК-тай 21.4 тэрбум төгрөгтэй тэнцэх ам.долларыг 2 сарын дараа худалдах форвард хэлцлийг хамгийн бага зардлаар гүйцэтгэж, ханшийн эрсдлийг нь буурууллаа.

Ийнхүү оролцогч банкуудтай санхүүгийн үүсмэл хэрэгслийн гэрээ байгуулсан хэрэгжүүлэгч **11 компани нь нийтдээ 115.4** тэрбум төгрөгийн **2-6** сарын дараа худалдах форвард хэлцлийг хамгийн бага зардлаар гүйцэтгэж, ханшийн эрсдлийг нь буурууллаа.

Дэд хөтөлбөрийн хэрэгжилт болон хөтөлбөрийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Монголбанкны цахим хуудасны [“Үнийг тогтворжуулах хөтөлбөр”](#) цэснээс үзнэ үү.

--- оОо ---